



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/2021/Н

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн Албан бус-Насан  
туршийн боловсролын төвийн  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 716,921.60 (долоон зуун арван зургаан мянга есөн зуун хорин нэгэн төгрөг жаран мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв (Т.Рэгзэдмаа)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 293,831.60 (хоёр зуун ерэн гурван мянга найман зуун гучин нэгэн төгрөг жаран мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн устгах, 2 нэр төрлийн 423,090 (дөрвөн зуун хорин гурван мянга ер) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 25,000 (хорин таван мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 7,500 (долоон мянга таван зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв (Т.Рэгзэдмаа)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000687

